



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2020 ОН



Улаанбаатар хот
2021 он

1	АПУ ХК	643.99	16	МАНДАЛ ДААТГАЛ	29.97
2	ТАВАН ТОЛГОЙ	371.82	17	ГУТАЛ	27.68
3	МИК ХОЛДИНГ	309.60	18	МОНОС ХҮНС	27.39
4	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	229.85	19	ШИВЭЭ ОВОО	26.82
5	ИНВЕСКОР ББСБ	212.39	20	ЛЭНДМН ББСБ ХК	25.15
6	ГОВЬ	150.17	21	АРД КРЕДИТ ББСБ Х	22.99
7	МОНГОЛ ДААТГАЛ	116.72	22	БАГАНУУР	21.08
8	МОНГОЛ ШУУДАН ХК	74.69	23	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	20.06
9	СҮҮ	70.52	24	АРД ДААТГАЛ ХК	20.00
10	УБ-БҮК	52.62	25	ТАЛХ ЧИХЭР	16.84
11	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	52.17	26	БИ ДИ СЕК	16.80
12	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	50.30	27	ДАРХАН НЭХИЙ	16.45
13	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	45.27	28	ТАХЬ-КО	14.67
14	ТҮМЭН ШУВУУТ	33.80	29	ТЕХНИК ИМПОРТ	12.64
15	БОДЬ ДААТГАЛ	30.59	30	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	11.81
Нийт дүн					2,754.85
Нийт ЗЗҮ-нд эзлэх хувь					90.93%

1.2. Хөрвөх чадвар

Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр дэлхийн улс орнуудын хөрвөх чадварын дундаж үзүүлэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 88.4 хувь байгаа бол Монгол Улсын багтдаг ангилал буюу дунджаас бага орлоготой орнуудын дундаж үзүүлэлт 45.4 хувь байна.

Харин Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 оны жилийн эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулахад 12.15 хувиар өссөн боловч хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 42.7 тэрбум төгрөгөөр буурсан нь хөрвөх чадварын үзүүлэлтэд голчлон нөлөөлж, өмнөх оны үзүүлэлтээс 1.79 нэгжээр бууран 1.6 хувь болсон байна.

Хөрвөх чадварын үзүүлэлт олон улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй хамааралтай байна.

Тухайлбал, ТОП-20 индексэд багтаж буй компаниудын хувьцаа эзэмшлийн хувь хэмжээг харахад нийт хувьцааны 80.3 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн 0.05 хувь нь эзэмшиж байна.

1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд


Монголын хөрөнгийн бирж дээр ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 19,511.49 нэгж, доод үзүүлэлт 15,914.15 нэгж, дундаж үзүүлэлт 17,398.41 нэгж байна.

ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 336.06 нэгжээр буюу 1.71 хувиар буурч, 19285.80 нэгж болсон байна. Индексийн бууралтад индексийн сагсыг

бүрдүүлж буй “Монгол базальт” ХК /-30.29%/, “Говь” ХК /-28.70%/, “Лэндмн” ББСБ ХК /-26.40%/, “Шарын гол” ХК /-22.03%/ -ийн ханш тус тус буурсан нь нөлөөлсөн байна (www.mse.mn, 2021).

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иас 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон. MSE-A индекс өмнөх оны мөн үеэс 409.65 нэгжээр буюу 4.3 хувиар буурсан бол MSE-B индекс өмнөх оны мөн үеэс 369.6 нэгжээр буюу 4.7 хувиар буурсан байна.

График 2. Индексийн үзүүлэлт




ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт

Тайланг хугацаанд анхдагч болон хоёрдогч зах зээл дээр нийт 65.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагууд дээр өмнөх онуудад зөвхөн хувьцаа, өрийн хэрэгсэл, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020 онд анх удаа хамтын хөрөнгө оруулалтын сан СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авснаар тус сангийн нэгж эрх арилжаалагдаж эхэлсэн. Ингэснээр нийт арилжааны 82.48 хувийг хувьцаа, 8.86 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 7.76 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 0.9 хувийг ЗГҮЦ-ны арилжаа тус тус эзэлж байна. Үүнд:

График 3. Арилжааны хэмжээ-Бүтээгдэхүүнээр /төгрөгөөр/



Нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 58.0 хувиар буурсанд хувьцааны арилжаа 59.7 хувь, ЗГҮЦ-ны арилжаа 93.9 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Харин хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд зөвхөн 5 төрлийн нийт 488.7 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 216.3 тэрбум төгрөгөөр буюу 30.7 хувиар буурсан байна.

2.1.1. Хувьцааны арилжаа

2020 онд нийт 53.9 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 59.7 хувиар буурсан бөгөөд үүнд анхдагч зах зээлийн арилжаа 87.47 хувиар, хоёрдогч зах зээлийн арилжаа 46.76 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

“МХБ” ХК-иар 2020 онд 50,359 хэлцэл хийгдэж, нийт 144 компанийн 353,252,857 ширхэг хувьцааг арилжаалагдсан бол “МҮЦБ” ХК-иар 290 хэлцэл хийгдэж, Анд-Энерги” ХК-ийн 746,000 ширхэг хувьцаа арилжаалагдсан байна.

График 4. 2020 онд хийгдсэн хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/



Дээрх графикт тусгагдсанаар 2020 оны 12 дугаар сард хамгийн их арилжаа хийгдсэн байх бөгөөд үүнд нийт 4.2 тэрбум төгрөгийн багцын арилжаанууд нөлөөлсөн байна.

Анхдагч зах зээлийн арилжааны хувьд 2019 онд “Түмэн шувуут”, “Ард Кредит ББСБ”, “Монос хүнс”, “Инвекор ББСБ” компаниуд IPO хийж, нийт 42.46 тэрбум төгрөгийн арилжаа анхдагч зах зээл дээр хийгдэж байсан бол энэ онд “Бодь даатгал” компани IPO хийж нийт 5.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Харин хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллагууд дээр бүртгэлтэй нийт 193 компаниар ангилвал 20 компанийн хувьцааны арилжааны дүн нийт арилжааны 90.7 хувийг бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 2. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компани

№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн
1	ИНВЕСКОР ББСБ	6,008,991,791.00
2	МИК ХОЛДИНГ	5,183,230,460.00
3	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	4,411,534,408.00
4	МОНГОЛ ШУУДАН ХК	3,650,900,546.70
5	БОДЬ ДААТГАЛ	3,461,468,721.87
6	ЖЕНКО ТУР БЮРО	2,871,203,241.81
7	АРД КРЕДИТ ББСБ ХК	2,477,801,245.92
8	АПУ	2,427,701,174.05
9	ЛЭНДМН ББСБ ХК	2,353,912,547.97
10	МАНДАЛ ДААТГАЛ	1,882,699,439.92
11	МОНОС ХҮНС	1,651,623,642.23
12	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,325,741,928.00
13	АРД ДААТГАЛ ХК	1,177,652,456.51

14	МАХИМПЕКС	1,077,220,314.00
15	ГОВЬ	780,044,366.31
16	ХАЙ БИ ОЙЛ	770,618,881.21
17	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИОН ХК	662,167,206.94
18	ТҮМЭН ШУВУУТ	642,882,479.67
19	ТАВАН ТОЛГОЙ	629,957,389.00
20	АДУУН ЧУЛУУН	628,991,480.80
НИЙТ		44,076,343,721.91

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

2.1.1.1. Багцын арилжаа

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаанд багцын арилжааны эзлэх хувь 2018 онд 71.22 хувь, 2019 онд 61.24 хувь байсан бол 2020 онд нийт 15.8 тэрбум төгрөгийн багцын арилжаа хийгдсэнээр нийт хоёрдогч зах зээлийн арилжааны 32.67 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Багцын арилжаа


Он	Хоёрдогч зах зээлийн арилжаа	Багцын арилжаа	Багцын арилжааны эзлэх хувь
2018	178,861,164,053.00	127,385,368,234.13	71.22%
2019	91,291,309,491.00	55,907,890,997.23	61.24%
2020	48,607,756,886.00	15,881,656,485.21	32.67%

Тайланг хугацаанд багцын арилжаагаар “Лэндмн ББСБ”, “Хай би ойл” “Даваанбулаг”, “Дорнод авто зам”, “Монгол шуудан”, “Ард кредит ББСБ”, “Монос хүнс”, “Хөнгөн бетон”, “Инвекор ББСБ”, “Женко тур бюро”, “Булган ундарга”, “Мандал даатгал”, “Түмэн шувуут”, “Адуунчулуун”, “Бодь даатгал” зэрэг ХК-иудын нийт 131.2 сая ширхэг хувьцааг 15.8 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

2.1.2. ЗГҮЦ-ны арилжаа

ЗГҮЦ 2018 оноос эхлэн анхдагч зах зээл дээр гараагүй бол 2020 онд ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 5.8 мянган ширхэг үнэт цаасыг 586.9 сая төгрөгөөр арилжаалсан байна.

График 5. ЗГҮЦ-ны арилжаа /тэрбум төгрөгөөр/



2.1.3. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2001-2019 онуудад нийт 16 компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргасан бол 2020 онд “Лэндмн ББСБ” ХК-иас нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 17 хувийн хүүтэй нийт 5.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 50.0 мянган ширхэг өрийн хэрэгслийг гаргасан. Харин хоёрдогч зах

зээлийн арилжаагаар тус компанийн нийт 793.6 сая төгрөгөөр 7,918 ширхэг өрийн хэрэгсэл арилжаалагдсан байна.


2.1.4. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд 2020 оны байдлаар нийт 23 хөрөнгө оруулалтын менежментийн компани бий болж хувийн хөрөнгө оруулалтын сангууд удирдаж ирсэн бол 2020 онд анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох “Үндэсний хувьчлалын сан” СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авч, анхдагч зах зээл дээр нийт 4.75 тэрбум төгрөгийн нэгж эрх арилжаалагдаж, хоёрдогч зах зээл дээр нийт 321.2 сая төгрөгийн 2,998,594 ширхэг нэгж эрх арилжаалагдсан байна.

2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн биржээр нийт 488.7 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 216.3 тэрбум төгрөгөөр буюу 30.7 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд дараах 5 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 6. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



2.1.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар байдлаар “МИК ОССК” ХХК-иас 24 тусгай зориулалтын компани /ТЗК/-ийг үүсгэн байгуулж, нийт 83,674 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-нд бүртгүүлээд байна.

Монгол Улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үл хөдлөх хөрөнгийн зээлээр баталгаажуулж ирсэн бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 64,536 зээлдэгчийн 3.0 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаас байна.

Мөн үүрэн телефоны оператор болох “Жимобайл” ХХК нь 2019 оны 5 дугаар сард нийт 7.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаажсан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 2.375 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Мөн энэ онд Ковид-19 цар тахлын онцгой нөхцөлд ажиллаж буй төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны хөтөлбөрт хамруулах хүрээнд анхны

түрээсийн үйл ажиллагаанд түшиглэсэн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарлаа. Хэдийгээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль батлагдсанаас хойш 10 орчим жилийн хугацаа өнгөрсөн ч энэ төрлийн үнэт цаасыг зөвхөн цөөн тооны мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж байсан бол 2020 онд анх удаа автомашины зээлээр баталгаажсан нийтэд буюу иргэдэд чиглэсэн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн СЗХ-нд бүртгүүлсэн.

2.2. Үнэт цаасны зах зээлийн эрэлт

“Монголын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас ирүүлсэн тайлангаар тайлант хугацаанд 558,098 данс шинээр нээгдсэнээр үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжинд өссөн дүнгээр нийт 2,385,822 данс нээгдсэн байна. Мөн онд 159,559 холболтын данс нээгдэж нийт 377,434 холболтын данс нээгджээ. Төвлөрсөн хадгамжид нээгдсэн нийт данснаас 2,380,421 дотоодын иргэн, 2,331 гадаадын иргэн, 2,872 дотоодын аж ахуйн нэгж, 198 гадаад аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

“Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-иас ирүүлсэн тайлангаар тайлант хугацаанд гадаадын ААН, гадаадын иргэдийн хийсэн арилжаа нийт хийгдсэн арилжааны 13.14 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 10.47 нэгжээр буурсан байна.

Нийт арилжаанд дотоодын аж ахуйн нэгж 55.48 хувь, дотоодын иргэн 28.55 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. Хөрөнгө оруулагчдын эзлэх хэмжээ /сая төгрөгөөр/

Он	Гадаадын ААН	Гадаадын иргэн	Дотоодын ААН	Дотоодын иргэн	Нийт
2019 он	19,393.56	14,518.14	69,260.33	40,476.63	143,648.66
	13.50%	10.11%	48.22%	28.18%	100%
2020 он	259.01	6,548.02	28,735.58	14,786.71	51,798.76
	0.50%	12.64%	55.48%	28.55%	100%

Хэдийгээр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д өссөн дүнгээр нийт 2,385,822 данс нээгдээд байгаа хэдий ч 2020 онд 8,070 этгээд арилжаанд оролцжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг СЗХ хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан 137, үнэт цаасаа бүртгүүлсэн 314 ХК, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг нь бүртгэсэн 19, үнэт цаасны зах зээлд хууль, үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн 118 этгээд байна.

Хүснэгт 5. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
---	-----------------------	-----

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага	2
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	23
5	Хамтын хөрөнгө оруулалтын сан	1
6	Кастодиан	3
7	Үнэт цаасны компани /брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх/	55 ¹
8	Хөрөнгө итгэмжлэн удирдах	7
9	Үнэт цаасны итгэмжлэн удирдах	1
10	Хөдөө аж ахуйн бирж	1
11	Хөдөө аж ахуйн брокер	14
12	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах	29
Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн		
13	Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгээ бүртгүүлсэн	19
Бүртгэлтэй ХК-ийн тоо		
14	Хувьцаат компани	314
Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн байгууллагууд		
15	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	59
16	ҮЦЗЗ-д оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	25
17	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	34

Тайлант хугацаанд СЗХ-ны тайлан тэнцлийн цахим системд тайлангаа ирүүлсэн ҮЦК, ХОМК, ХААБ-уудын нэгтгэлийг хураангуй байдлаар үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6. Балансын хураангуй /төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	ҮЦК	ХОМК	ХААБрокер
1	Эргэлтийн хөрөнгө	102,668,258,193.62	30,277,250,031.36	2,890,976,881.54
2	Эргэлтийн бус хөрөнгө	9,791,786,801.01	3,327,542,900.02	435,529,196.00
3	Нийт актив	112,460,044,994.63	33,604,792,931.38	3,326,506,077.54
4	Өр төлбөр	38,740,039,744.90	2,116,590,752.66	1,645,770,989.20

¹ Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк орсон болно.

5	Эздийн өмч	73,720,005,249.73	31,488,202,178.72	1,680,735,088.35
6	Нийт пассив	112,460,044,994.63	33,604,792,931.38	3,326,506,077.55

Салбарын нэгтгэлд хамрагдсан 53 ҮЦК-иудын² нийт актив тайлант үеийн байдлаар 112.5 тэрбум төгрөг байгаагаас 91.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 8.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлжээ³. Харин нийт пассивын 34.4 хувийг өр төлбөр, үүнээс богино хугацаат өр төлбөр 20.83 хувь, 12.37 хувийг нь урт хугацаат зээл бүрдүүлж байгаа бол нийт пассив талын үлдсэн 65.6 хувийг эздийн өмч, үүнээс 7.5 хувийг нэмж төлөгдсөн капитал, 3.9 хувийг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, эздийн өмчийн бусад хэсэг 2.6 хувь, хуримтлагдсан ашиг 9.2 хувийг тус тус эзэлж байна. Салбарын нэгтгэлд хамрагдсан нийт 53 ҮЦК-иас 2020 онд 29 компани нь нийт 2.77 тэрбум төгрөгийн алдагдалтай, үлдсэн 24 компани нь нийт 3.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орлогын хувьд 53 ҮЦК-ийн үйл ажиллагааны орлого 11.85 тэрбум төгрөг, үүнээс брокерийн орлого 53.2 хувь, андеррайтерийн орлого 28.0 хувь, дилерийн орлого 0.8 хувь, хөрөнгө оруулалтын зөвлөхийн орлого 8.8 хувийг тус тус эзэлж байна.

Харин СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан нийт 23 хөрөнгө оруулалтын менежментийн компаниудаас 8 нь СЗХ-ны тайлан тэнцлийн цахим системд тайлангаа ирүүлсэн бөгөөд тэдгээрийн нийт актив 33.6 тэрбум төгрөг байгаагаас 90.1 хувийг эргэлтийн хөрөнгө, 9.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Нийт пассивын 93.7 хувийг эздийн өмч, үлдсэн 6.3 хувийг өр төлбөр эзэлж байна.

Мөн хөдөө аж ахуйн брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 14 компаниас 7 нь цахим системд тайлангаа ирүүлж нэгтгэлд хамрагдсан байна. Эдгээр 7 компанийн нийт актив 3.3 тэрбум төгрөг үүний 86.9 хувийг эргэлтийн хөрөнгө, 13.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Харин нийт пассивын 49.5 хувийг богино хугацаат өр төлбөр, үлдсэн 50.5 хувийг эздийн өмч тус тус эзэлж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР СЗХ-НООСАВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

СЗХ-ноос 2020 онд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 1. Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх тухай асуудлыг СЗХ-ны 01 дүгээр сарын хурлын 29 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлж, дэд бүтцийн байгууллагууд болон зах зээлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд СЗХ-ны удирдлага дор бэлтгэл ажлыг ханган 2020.03.31-ний өдөр системийн хэмжээнд энэхүү горимд шилжсэн.**

Ингэснээр хөрөнгө оруулагчид өөрийн эрсдэлийг үнэлүүлсний үндсэн дээр 100 хувийн эх үүсвэрээ байршуулалгүйгээр өөрийн эрсдэлд уялдсан байдлаар захиалгын дүнгийн 30 хувь хүртэл бууруулсан хэмжээгээр эх үүсвэр байршуулан захиалга өгч арилжаанд оролцох, захиалга биелсэн нөхцөлд үлдэгдэл төлбөрийг шилжүүлэх боломж бий болохын зэрэгцээ, дэд бүтцийн байгууллагууд брокер, дилерийн компаниудаас авдаг шимтгэл хураамж буурах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон.

² 4 ҮЦК нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлээгүй бөгөөд хамгийн сүүлд ирүүлсэн тайлангийн үзүүлэлтээр орсон болно.

³ Үүнд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк ороогүй болно.

- 2. Хувьцаат компаниудын ногдол ашгийг түргэн шуурхай, хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл багатайгаар хуваарилах үүднээс ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох асуудлыг СЗХ-ны 01 дүгээр сарын хурлын 28 дугаар тогтоолоор шийдвэрлүүлж, зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан тараахыг хувьцаат компаниудад үүрэг болгосон.**

Энэхүү шийдвэрийн хүрээнд хувьцаат компаниуд жил бүр өөрийн байран дээр ногдол ашгийг тараах явдал зогсож, хувьцаа эзэмшигч нэг удаа үнэт цаасны данс нээлгүүлэн, мөнгөн гүйлгээ хийх дансаа баталгаажуулснаар орон зай харгалзалгүйгээр өөрийн харилцдаг банкнаасаа ногдол ашгаа бэлэн мөнгөжүүлж, цаашлаад энэ дансаараа дамжуулан арилжаанд оролцох, эргээд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломж бүрдсэн.

- 3. Бодлогын арга хэмжээнүүдийн хүрээнд өмнө нь батлагдаад хэрэгжүүлэх шатанд засах шаардлага нөхцөл үүсээд байсан хоёр журмыг зах зээлийн бодит нөхцөл байдалд нь уялдуулан зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагуудын санал, олон улсын зарчимд нийцүүлэх замаар өөрчлөлтүүдийг оруулж баталсан.**

- 2015 онд баталсан “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам”-ыг СЗХ-ны 2020 оны 8 дугаар сарын хурлаар шинэчлэн баталсан. Энэхүү журмаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг боловч бусад орны томоохон биржүүд дээр хувьцаа нь арилжаалагддаг компаниуд хадгаламжийн бичиг гаргах замаар дотоодын хөрөнгө оруулагчдаар хөрөнгө оруулагчдын бааз, сууриа тэлэх, нэмэлт эх үүсвэр татах боломжийг зохицуулсан ба журмыг илүү тодорхой болгож бодит нөхцөл байдалд нь уялдуулж өгсөн.
- 2018 онд баталсан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-д бирж хооронд хувьцаа хөрвөх нөхцөл буюу арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшиж байгаа иргэд хувьцаагаа гадаадын хөрөнгийн бирж рүү нь хөрвүүлбэ гэвэл “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан хийх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулж 2020 оны 8 дугаар сард баталсан. Үүний хүрээнд “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн Канад Улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт хувьцааг Монгол Улсад давхар бүртгэлээ.

- 4. Зээлийг хүүг буюу зах зээл дээрх санхүүжилтийн өртгийг хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, банкны зээлтэй өрсөлдөхүйц бүтээгдэхүүн бий болгох замаар бууруулах зорилгод чиглэсэн арга хэмжээнүүдийг “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д тусгалаа.**

Энэхүү арга хэмжээтэй холбоотойгоор СЗХ-ны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар холбогдох төр, хувийн хэвшил, дэд бүтцийн байгууллагууд, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдаж, 8 чиглэлээр дэд ажлын хэсгүүдэд хуваагдан ажиллаж байна. Ажлын хэсгүүдээс холбогдох журмууд боловсруулах, стратегид тусгагдсан ажлуудтай холбоотойгоор шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт боловсруулах ажлуудыг хийж байна.

- 5. Мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт чиглэсэн биржийн бус зах зээлийн нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох, олон улсын жишигт нийцсэн биржийн бус зах зээлийг хөгжүүлэх үндэс суурийг тавих зорилгоор “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг батлав.**

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа нээгдсэнээр компаниудын хувьд хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах эрх зүйн орчин бүрдэж, үнэт цаас гаргахад цаг хугацаа, зардал хэмнэхээс гадна хөрөнгө оруулагчид хаалттай хүрээнд гаргасан өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээл дээр арилжаалах, үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах, мэдээллийн ил тод байдал хангагдах зэрэг чухал ач холбогдолтой. Мөн нийгэд санал болгон гаргах үнэт цаасны шаардлага, шалгуурыг хангахад хүндрэлтэй байгаа жижиг, дунд үйлдвэрлэгч нарт биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох таатай нөхцөл бүрдэнэ.

6. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, мэргэжлийн оролцогч зуучлагч чадавхжуулж, үнэт цаасны зах зээлд шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр Мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны зохицуулалтын орчинг бүрдүүлсэн.

Ингэснээр үнэт цаасны зах зээлд оролцогч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг түргэн шуурхай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өмчлөх эрхийн шууд хэлбэрийн тогтолцоонд шилжүүлж, үйчилгээ үзүүлэгчид тавигдах санхүү, хүний нөөц, програм хангамж, удирдлага, зохион байгуулалтын шаардлагыг чанаржуулж, үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлсэн шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

7. СЗХ-ны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсрууллаа.

Үнэт цаасны бүртгэлийн журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа олон улсад мөрдөгдөж буй зохицуулалт, зарчмыг тусгахаас гадна үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогчдод хүндрэл учруулж буй зохицуулалтыг арилгах, нийгэд санал болгон анх удаа болон нэмж хувьцаа гаргахтай холбоотой харилцааг олон улсын жишигт нийцүүлэх, анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулах, үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлсэн. Журмын төслийг эцэслэн боловсруулж олон нийгээс санал авах ажиллагааг эхлүүлсэн.

8. “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын төслийг шинээр боловсрууллаа.

СЗХ-ны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д компанийн өрийн хэрэгслийн зохицуулалт тусгагдсан хэдий ч хувьцааны бүртгэлийн шаардлага шалгууртай ижил төстэй, Үнэт цаасны тухай хуулийн 9.3, 9.4-д заасны дагуу хаалттай өрийн хэрэгслийг СЗХ-нд бүртгүүлэх зохицуулалт, мөн засаглал, ил тод байдлын талаарх зохицуулалт бүрхэг байсан зэрэг асуудлуудыг тодорхой болгож, зах зээлд оролцогчдод хүндрэл учруулж буй зохицуулалтыг арилгах, олон улсын зохицуулалт, зарчмыг тусгасан журмын төслийг шинээр боловсруулж, санал авахаар бэлтгэж байна.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР